



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 19/76

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 98 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Байгаль хамгаалах сангийн 2023 оны санхүүжилтээр хийгдэх “Шилийн зооны Оросын туурийг цэвэрлэх, нөхөн сэргээлт хийх” ажлыг 10,000,000 (арван сая) төгрөгөөр Б.Дарханбаяртай шууд гэрээ байгуулсугай.

2. “Шилийн зооны Оросын туурийг цэвэрлэх, нөхөн сэргээлт хийх” ажлыг ажлын даалгаварын дагуу гүйцэтгэхийг (Б.Дарханбаяр)-т даалгасугай.

3. Б.Дарханбаяртай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Бөхт багийн Засаг дарга (М.Цэвэгдорж)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ